

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ДАХИН ОЛГОХ ДАРААЛАЛ

1. **WWW.MCIS.GOV.MN** сайтад хандаж Барилгын материал цэсний Холбогдох баримт бичиг хэсгээс **СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА**-тай танилцах, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”, Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагатай танилцах
2. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь төрийн мэдээллийн сангуудтай холбогдсон тул тус цахим программд бүртгүүлэх инженер, техникийн ажилтнууд **E-Mongolia** платформд бүртгүүлсэн байх
3. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн **ГЭРЧИЛГЭЭГ ГЭЭСЭН, ҮРЭГДҮҮЛСЭН** шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргах бол дээр дурьдсан 1, 2-т заасан мэдээллийг цахим системд бүртгүүлэхээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
 - Албан хүсэлт
 - Гэрчилгээг гээсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулсан хуулбар
 - ААНБ-ууд нь үйл ажиллагааны тайлан мэдээгээ БХТ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэст хагас жил тутам илгээж, БМҮТЗ-ийн хавсралтад тэмдэглэл хийлгэсэн байх БМҮТЗ авснаас хойш гүйцэтгэсэн ажлын тайланг /www.mcis.gov.mn сайтад гүйцэтгэсэн ажлын тайлан хэсэгт ажлын гэрээг хавсаргах, БМҮТЗ авснаас хойшхи хугацаанд шимтгэл төлсөн баримтын хуулбарыг хавсаргах, Барилгын норм, норматив боловсруулах сангийн шимтгэлийг /төсөвт өртгийн 0,18 хувиар/ төлсөн байна.
4. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн **ОНООСОН НЭР, ЭЗЭМШИГЧИЙН НЭР ӨӨРЧЛӨГДСӨН** шалтгаанаар тусгай зөвшөөрлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах бол дээр дурьдсан 1, 2-т заасан мэдээллийг цахим системд бүртгүүлэхээс гадна бол дор дурдсан баримт бичгийг дээр дурьдсан 1, 2-т заасан мэдээллийг цахим системд бүртгүүлэхээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
 - Улсын бүртгэлийн лавлагаа
 - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - Хуулин этгээдийн дүрмийн хуулбар
 - Эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
 - ААНБ-ууд нь үйл ажиллагааны тайлан мэдээгээ БХТ-ын Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэст хагас жил тутам илгээж, БМҮТЗ -ийн хавсралтад тэмдэглэл хийлгэсэн байх БМҮТЗ авснаас хойш гүйцэтгэсэн ажлын тайланг /www.mcis.gov.mn сайтад гүйцэтгэсэн ажлын тайлан хэсэгт ажлын гэрээг хавсаргах, БМҮТЗ авснаас

хойшхи хугацаанд шимтгэл төлсөн баримтын хуулбарыг хавсаргах,
Барилгын норм, норматив боловсруулах сангийн шимтгэлийг /төсөвт
өртгийн 0,18 хувиар/ төлсөн байна.

5. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС /420 000 төгрөг/төлсөн төлбөрийн баримт
хавсаргах

МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО
УТАС: 316253, 99262172, 99143658, 99015759